

**ЧАНАРЫН ГАРЫН АВЛАГА, МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЖУРМЫН ТӨСЛИЙГ
БОЛОВСРУУЛАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ТЕХНИКИЙН ТАЙЛАН**

Эм, эмнэлгийн хэрэгсэл хяналт зохицуулалтын газар ДЭМБ-ын тусламжтайгаар зохицуулалтын чиг үүргийг нэг дор төвлөрүүлэн, хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан Эм шинжлэх лабораторийн чанарын гарын авлага, менежментийн тогтолцооны журам, баримтлах бодлого, зохицуулалтын үйл ажиллагааны дүрэм, журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

MNS/ISO/IEC 17025:2018 стандартын дагуу Чанарын гарын авлага, менежментийн тогтолцооны журмыг боловсруулснаар журамд тусгагдаагүй зохицуулалтын заалтуудыг нарийвчлан оруулж, үндэсний давтан итгэмжлэлд амжилттай хамрагдах, ажилчдын чадавхижуулах сургалтыг зохион байгуулсан нь их ач холбогдолтой байлаа.

Эм, эмнэлгийн хэрэгсэл хяналт зохицуулалтын газрын даргын 2023 оны 03 сарын 01-ний өдрийн А/35 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг 56 журмыг боловсруулахаар төлөвлөсөн.

Төлөвлөгөөт хугацаанд ажлын хэсгийн 2 удаагийн уулзалт, сургалт, хэлэлцүүлэг хийсэн. Үүнд

1. ЭЭХХЗГ-ын Эм шинжлэх лабораторийн Чанарын гарын авлага, менежментийн тогтолцооны журмын төслийг MNS/ISO/IEC 17025:2018 стандартад нийцүүлэн боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулсан
2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу “Эмийн лабораторийн зохистой дадал”-ыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, үйл ажиллагааны талаар баримтлах бодлого, зохицуулалтын үйл ажиллагааны дүрэм, журам, бүртгэлийн маягтыг шинэчлэсэн.

1.ЭЭХХЗГ-ын даргын 2023 оны А/14 тушаалын дагуу Эм шинжлэх лабораторийн Чанар хариуцсан ахлах мэргэжилтэн, Техник хариуцсан ахлах мэргэжилтэн, химийн лабораторийн ахлах шинжээч, микробиологийн лабораторийн ахлах шинжээч нар нь “Чанарын гарын авлага, менежментийн тогтолцооны журам”-ыг MNS/ISO/IEC 17025:2018 стандартын дагуу олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан.

2. MNS/ISO/IEC 17025:2018 стандартын дагуу Чанарын гарын авлагыг нэгдүгээр хавсралтаар, менежментийн тогтолцооны журмыг хоёрдугаар хавсралтаар боловсруулсан сэдвийг үзүүлэв.

Тайланд холбогдох зураг, оролцогчдын гарын үсэг баримтжуулалтыг хавсаргав.

Санхүүжүүлэгч байгууллага:

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, нийт үнэ 8,750,000 (найман сая долоон зуун тавин мянган төгрөг)

Техникийн тайлан гаргасан:

Эм шинжлэх лабораторийн Чанар хариуцсан ахлах мэргэжилтэн

Ш. Сонинхүү

Ш.Сонинхүү